БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/147/СТА-ТШЗ

---

Баянхонгор
2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Баянташаагийн эх аудит” ХХК-ийн аудитор: Ч.Чимгээ

Утас: 89915909 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ .......... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .......... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .......... 11
3.Аудитын тайлан .......... 11
3.1. Ерөнхий зүйл .......... 11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .......... 12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .......... 12
3.4. Материаллаг байдал .......... 13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .......... 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .......... 14
3.7. Шилэн дансны мэдээлэл .......... 15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 15
3.9. Аудитын илрүүлэлт .......... 15
Залруулсан алдаа .......... 16
Аудитын зөвлөмж .......... 16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .......... 16
4. Менежментийн захидал .......... 16
6 Хавсралт. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .......... 188



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.18 № 2/140

танай ____________ -ны №____________ -т

Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СОДНОМЧИМЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

6417143544
ВЮА0067 9007423

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| 1. Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,242,228.87** | **68,514,779.87** |
| **33** | **АВЛАГА** | 1,017,482.97 | 2,562,713.97 |
| | | | |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 485,319.97 | 510,550.97 |
| **335** | **Бусад авлага** | 532,163.00 | 2,052,163.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 532,163.00 | 2,052,163.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,224,745.90 | 65,952,065.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 51,224,745.90 | 65,952,065.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 119,000.00 | 499,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 48,715,642.90 | 62,787,302.90 |
| 35460 | Хүнсний материал | 1,152,603.00 | 1,640,263.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,237,500.00 | 1,025,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **927,827,627.14** | **921,337,544.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 927,827,627.14 | 921,337,544.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 920,347,627.14 | 913,857,544.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 969,395,186.90 | 969,395,186.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -66,030,848.13 | -82,181,416.01 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,310,114.00 | 27,101,514.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18,493,252.45 | -16,404,401.02 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,571,098.00 | 41,595,738.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,313,671.18 | -27,558,076.90 |
| 39217 | Ном | 1,909,000.00 | 1,909,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,480,000.00 | 7,480,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 00.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,480,000.00 | 7,480,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **980,069,856.01** | **989,852,324.84** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,043,101.00** | **2,074,167.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,043,101.00 | 2,074,167.00 |
| **413** | **Өглөг** | 2,043,101.00 | 2,074,167.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 31,066.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,362,800.00 | 1,362,800.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 680,301.00 | 680,301.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 680,301.00 | 680,301.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **978,026,755.01** | **987,778,157.84** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 978,026,755.01 | 987,778,157.84 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 100,436,916.11 | 100,436,916.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 100,436,916.11 | 100,436,916.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -20,692,119.52 | -10,710,716.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -20,692,119.52 | -20,462,119.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 9,751,402.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 898,281,958.42 | 898,051,958.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **980,069,856.01** | **989,852,324.84** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **312,313,708.00** | **293,617,870.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **12,384,662.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 12,384,662.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 12,384,662.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 12,384,662.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **312,313,708,00** | **281,233,208,00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 284,130,500.00 | 251,670,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,364,908.00 | 5,951,108.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,364,908.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,951,108.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,818,300.00 | 23,611,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,818,300.00 | 23,611,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **318,754,079.87** | **283,050,523.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **318,754,079.87** | **283,050,523.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 317,031,958.87 | 275,201,101.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 165,648,265.00 | 185,407,509.00 |
| 210101 | Үндсэн цалин | 163,581,756.00 | 130,183,349.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,066,509.00 | 43,347,249.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 11,876,911.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,009,835.00 | 23,361,721.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,394,667.00 | 15,820,121.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,999,516.00 | 1,900,808.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,427,183.00 | 1,520,646.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 587,261.00 | 372,010.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,601,208.00 | 3,748,136.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,679,017.00 | 19,478,376.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,571,100.00 | 1,311,768.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,907,917.00 | 17,757,608.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 409,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,730,720.00 | 5,776,679.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,382,020.00 | 624,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 540,000.00 | 2,593,980.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,021,550.00 | 1,120,499.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 110,000.00 | 52,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 108,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,497,150.00 | 1,277,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,410,865.40 | 14,537,770.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 38,000.00 | 172,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,372,865.40 | 14,365,270.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,754,000.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,754,000.00 | 200,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 70,000.00 | 96,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,000.00 | 96,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 560,100.00 | 6,874,508.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 360,100.00 | 6,624,508.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,169,156.47 | 19,468,538.05 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 130,000.00 | 611,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,039,156.47 | 18,857,538.05 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,722,121.00 | 7,849,422.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 82,000.00 | 104,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 82,000.00 | 104,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,629,491.00 | 4,145,624.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,629,491.00 | 4,145,624.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,630.00 | 3,599,798.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,630.00 | 3,599,798.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-6,440,371.87** | **10,567,346.95** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 815,944.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 815,944.12 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -815,944.12 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-6,440,371.87** | **9,751,402.83** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **312,756,830.00** | **281,233,208.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **312,756,830.00** | **281,233,208.00** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 284,130,500.00 | 251,670,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,364,908.00 | 5,951,108.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,364,908.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,951,108.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26,818,300.00 | 23,611,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,818,300.00 | 23,611,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 443,122.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 443,122.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **301,966,830.00** | **275,573,308.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **301,966,830.00** | **275,573,308.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **299,801,587.00** | **267,723,886.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 186,897,100.00 | 184,009,495.00 |
| 210101 | Үндсэн цалин | 162,305,400.00 | 128,495,562.76 |
| 210102 | Нэмэгдэл | 12,917,300.00 | 25,403,969.32 |
| 210104 | Урамшуулал | 11,674,400.00 | 29,443,802.92 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 666,160.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,761,000.00 | 24,753,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,753,900.00 | 17,419,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,746,000.00 | 1,833,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,402,900.00 | 1,466,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 350,800.00 | 366,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,507,400.00 | 3,667,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,553,717.00 | 19,265,876.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,571,100.00 | 1,311,768.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,782,617.00 | 17,545,108.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 409,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,555,740.00 | 5,649,579.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 74,900.00 | 87,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 440,000.00 | 2,593,980.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,367,040.00 | 1,383,499.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 41,400.00 | 52,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 534,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,452,400.00 | 997,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 47,082,600.00 | 19,864,430.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 38,000.00 | 1,842,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,423,100.00 | 14,852,930.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 621,500.00 | 3,169,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,987,000.00 | 5,799,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 4,446,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,987,000.00 | 1,353,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 70,000.00 | 96,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,000.00 | 96,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 497,800.00 | 6,448,108.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 297,800.00 | 6,198,108.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,396,630.00 | 1,836,998.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,396,630.00 | 1,836,998.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,165,243.00** | **7,849,422.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 525,122.00 | 104,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 443,122.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 82,000.00 | 104,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,629,491.00 | 4,145,624.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,629,491.00 | 4,145,624.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,630.00 | 3,599,798.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,630.00 | 3,599,798.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,790,000.00** | **5,659,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,790,000.00** | **5,659,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,790,000.00** | **5,659,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,790,000.00 | 5,659,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,790,000.00 | 5,659,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,790,000.00** | **-5,659,900.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100,436,916.11** | **898,281,958.42** | **-20,692,119.52** | 978,026,755.01 |
| D01 | **2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **100,436,916.11** | **898,281,958.42** | **-20,692,119.52** | 978,026,755.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 230,000.00 | 230,000.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **100,436,916.11** | **898,281,958.42** | **-20,462,119.52** | 978,256,755.01 |



005

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -230,000.00 | 00.00 | -230,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 9,751,402.83 | 9,751,402.83 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **100,436,916.11** | **898,051,958.42** | **-10,710,716.69** | 987,778,157.84 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 275,282,100.00 | 267,536,678.00 | -7,745,422.00 | 97.19 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 275,282,100.00 | 267,536,678.00 | -7,745,422.00 | 97.19 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 275,177,500.00 | 267,432,678.00 | -7,744,822.00 | 97.19 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187,065,200.00 | 184,009,495.00 | -3,055,705.00 | 98.37 |
| 210101 | Үндсэн цалин | 128,300,800.00 | 128,495,562.76 | 194,762.76 | 100.15 |
| 210102 | Нэмэгдэл | 25,749,600.00 | 25,403,969.32 | -345,630.68 | 98.66 |
| 210104 | Урамшуулал | 29,312,200.00 | 29,443,802.92 | 131,602.92 | 100.45 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,702,600.00 | 666,160.00 | -3,036,440.00 | 17.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,253,700.00 | 24,753,900.00 | -499,800.00 | 98.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,771,200.00 | 17,419,500.00 | -351,700.00 | 98.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,870,600.00 | 1,833,600.00 | -37,000.00 | 98.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,496,500.00 | 1,466,900.00 | -29,600.00 | 98.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 374,100.00 | 366,700.00 | -7,400.00 | 98.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,741,300.00 | 3,667,200.00 | -74,100.00 | 98.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,411,500.00 | 19,265,876.00 | -4,145,624.00 | 82.29 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,811,900.00 | 1,311,768.00 | -1,500,132.00 | 46.65 |
| 210302 | Түлш, халаалт | 20,190,600.00 | 17,545,108.00 | -2,645,492.00 | 86.90 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 409,000.00 | 409,000.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,662,600.00 | 5,649,579.00 | -13,021.00 | 99.77 |
| 210401 | Бичиг хэрэг | 94,500.00 | 87,500.00 | -7,000.00 | 92.59 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,600,000.00 | 2,593,980.00 | -6,020.00 | 99.77 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,383,500.00 | 1,383,499.00 | -1.00 | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 52,300.00 | 52,300.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал | 534,500.00 | 534,500.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 997,800.00 | 997,800.00 | 0.00 | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,870,900.00 | 19,864,430.00 | -6,470.00 | 99.97 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,848,800.00 | 1,842,500.00 | -6,300.00 | 99.66 |
| 210502 | Хоол, хүнс | 14,853,000.00 | 14,852,930.00 | -70.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,169,100.00 | 3,169,000.00 | -100.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,881,400.00 | 10,859,400.00 | -22,000.00 | 99.80 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,521,000.00 | 9,506,400.00 | -14,600.00 | 99.85 |
| 210604 | Урсгал засвар | 1,360,400.00 | 1,353,000.00 | -7,400.00 | 99.46 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 98,000.00 | 96,000.00 | -2,000.00 | 97.96 |
| 210702 | Дотоод албан томилолт | 98,000.00 | 96,000.00 | -2,000.00 | 97.96 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,097,200.00 | 1,097,000.00 | -200.00 | 99.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчи | 847,200.00 | 847,000.00 | -200.00 | 99.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1837000.00 | 1836998.00 | -2.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,837,000.00 | 1,836,998.00 | -2.00 | 100.00 |



005

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | дүн | хувь |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 104600.00 | 104000.00 | -600.00 | 99.43 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 104,600.00 | 104,000.00 | -600.00 | 99.43 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 104,600.00 | 104,000.00 | -600.00 | 99.43 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 275,282,100.00 | 267,536,678.00 | -7,745,422.00 | 97.19 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 251,670,600.00 | 248,070,802.00 | -3,599,798.00 | 98.57 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 251,670,600.00 | 248,070,802.00 | -3,599,798.00 | 98.57 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 23,611,500.00 | 19,465,876.00 | -4,145,624.00 | 82.44 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 23,611,500.00 | 19,465,876.00 | -4,145,624.00 | 82.44 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 20.00 | 20.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 188.00 | 188.00 | 0.00 | 100.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **20.00** | **20.00** | 0.00 | 100.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 12.00 | 12.00 | 0.00 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 08.00 | 08.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **5,951,108.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 5951108.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 5,951,108.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 5,951,108.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 5951108.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 5,951,108.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,951,108.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Содномчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ээс 2021 оны 02 дугаар сарын 18–ны хооронд "Баянташаагийн эх аудит" ХХК-ний аудитор Ч.Чимгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Тус цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Төрийн Аудитын газарт мөн оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 46 тоот албан бичгээр, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг "Баянташаагийн эх аудит" ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 03 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжих, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхэд хамгааллын талаарх бусад үндэсний бодлого, дүрэм,журам

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 318711.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6374.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 284944.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5698.9 мянган төгрөгөөр тооцов.

Гүйцэтгэлийн шатанд 3340,0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материал данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснийг материаллаг бус алдаанд тооцсон болно.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 989852,3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 9782,5 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 52,242.2 | 68,514.8 | 16,272.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,017.5 | 2,562.7 | 1,545.2 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 51,224.7 | 65,952.1 | 14,727.3 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 927,827.6 | 921,337.5 | (6,490.1) |
| Үндсэн хөрөнгө | 1,038,865.4 | 1,047,481.4 | 8,616.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (111,037.8) | (126,143.9) | (15,106.1) |
| **Нийт хөрөнгө** | 980,069.9 | 989,852.3 | 9,782.5 |
| Өр төлбөр | 2,043.1 | 2,074.2 | 31.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 978,026.8 | 987,778.2 | 9,751.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 980,069.9 | 989,852.3 | 9,782.5 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Тайлант онд эргэлтийн хөрөнгө 68514,8 мянган төгрөг болж, 16272,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь авлага 1545,2 мянган, бараа материалын үлдэгдэл 14727,3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой.

Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг 2020 оны 12 сарын 23-нд Тулга техник ХХК-д шилжүүлсэнтэй холбоотой авлага нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1047481,4 мянган төгрөг болж 8616,0 мянган төгрөгөөр өссөн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.



005

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 987778,2 мянган төгрөг болж 9751,4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 293617,9 мянган төгрөг болж, өмнөх оноос 18695,8 мянган төгрөгөөр буюу 6,0 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос 123844,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон тайлант онд тусламж санхүүжилтийн орлого 31080,5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тусламж санхүүжилтийн орлогыг нэр төрлөөр авч үзвэл тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 32459,9 мянган, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 3206,8 мянган төгрөгөөр тус тус буурсан, нэмэлт санхүүжилт 4586,2 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Бараа үйлчилгээний нийт зардал 275201,1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 41830,8 мянган төгрөгөөр буюу 15,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 19759,2 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 1299,3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4200,6 мянган, норматив зардал 31873,0 мянган, хангамж бараа материалын зардал 954,0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 259549.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 259549.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 15732.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж хоёр удаа тодотгол хийж 275282.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 275282,1 мянган төгрөгийн төсөв баталснаас 251670,6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 23611,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 248070,8 мянган, орон нутгийн төсвөөс 19465,9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 267536,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 7745,4 мянган төгрөг дутуу зарцуулсан нь цалингийн болон нийгмийн даатгалын зардлыг 3555,5 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4145,6 мянган, хангамж бараа материалын зардлыг 70,9 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 12,4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсөвт зардлыг дутуу зарцуулсан нь сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрийн байр ашиглалтын үйлчилгээний зардал 4145,6 мянган, сургалтын үйл ажиллагааны зардал 3599,1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 2.* Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71801 | Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр | 275282,1 | 267536,7 | (7745,4) | 97,1 |
| 1.1 | 81834 | Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагааны зардал | 236713,0 | 233113,9 | (3599,1) | 98,5 |
| 1.2 | 80109 | Байр ашиглалтын үйлчилгээ | 23611,5 | 19465,9 | (4145,6) | 82,4 |
| 1.3 | 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 14853,0 | 14852,9 | (0.1) | 100 |
| 1.4 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 104,6 | 104,0 | (0,6) | 99,43 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас 5951,1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан /тайлбарын хамт/ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг 11 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Хүснэгт 3.* www.shilendans.gov.mn цахим хуудсан дахь мэдээлэл

| Д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 7 | 2 | 3 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 8 | 8 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 88 | 8 | |
| | Нийт | 27 | 151 | 140 | 11 | |

*Эх сурвалж:* www.shilendans.gov.mn цахим хуудас

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРӨВ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5938,1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4418,1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1520,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материал дансанд зөөврийн компьютер 1725,0 мянган, өнгөт принтер 550,0 мянган, төмөр сейф 380,0 мянган, сэтгүүлийн цагаан ширээ 220,0 мянга, сандал 5ш 465,0 мянган төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг бүртгэсэн байна. Энэ үйлдэл нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.30-д Үндсэн хөрөнгийн "Хүлээн зөвшөөрөлт" хэсгийн "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө; хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба;хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалжээ.
   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Санхүүгийн тайлангийн аж ахуйн бараа материал дансанд бүртгэгдсэн 3340,0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д ".Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтыг үндэслэн тайлант үеийн үр дүнд залруулга хийв.

2. Зөрүүтэй бодогдсон цалингийн ажиллагсдаас суутгасан 1078,1 мянган төгрөгийн суутгалыг цалингийн өглөгөөр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг зөрчсөн байна.
   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10.-д заасан" аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэсэн заалтыг үндэслэн санхүүгийн тайланг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тухайн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1520,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

***1. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан /тайлбарын хамт/ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг 11 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-дэх " Энэ хуулийн 3.1.1;.3.1.2.-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"; 6.4-т " Энэ хуулийн 3.1.1; 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

*1.2. Эрсдэл*: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

1.3 *Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***2. Балансын данстай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:* Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д 2020 оны 12 сарын 23-нд шилжүүлж авлага үүссэн. Уг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн.

*2.2. Эрсдэл*: Үргүй зардал гарч, өр авлага нэмэгдэх

2.3 *Өгсөн зөвлөмж*: Тулга техник ХХКомпаниас гал тогооны дагалдах хэрэгслийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах" заалтыг мөрдөж өр авлага үүсгэхгүй ажиллах

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР — Ч.Чимгээ
Огноо: 2021.02.18

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.18

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.18



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | БНА-2021/147/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Эрдэнэцогт сумын цэцэрлэг | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардлыг 1078,1 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, өр төлбөрөөр тусгасан. | 1078,1 | Санхүүгийн тайланд залруулах | Эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч нягтлан бодогч | Ж.Содномчимэг С.Байгалмаа |
| 2 | Бараа материал дансанд зөөврийн компьютер 1725,0 мянган, өнгөт принтер 550,0 мянган, төмөр сейф 380,0 мянган, сэтгүүлийн цагаан ширээ 220,0 мянга, сандал 5ш 465,0 мянган төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг бүртгэсэн байна. | 3340,0 | Санхүүгийн тайланд залруулах | Эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч нягтлан бодогч | Ж.Содномчимэг С.Байгалмаа |
| 3 | Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан /тайлбарын хамт/ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг 11 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | 0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч нягтлан бодогч | Ж.Содномчимэг С.Байгалмаа |
| 4 | Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д 2020 оны 12 сарын 23-нд шилжүүлж авлага үүссэн. Уг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй | 1520,0 | Зөвлөмж өгөх | Эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч нягтлан бодогч | Ж.Содномчимэг С.Байгалмаа |
| **ДҮН** | | **5938,1** | | | |

---ооОоо--